

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2022 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.				
1	2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дүгээр тушаалаар баталсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ыг хүн амын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Иргэдийг дараах 6 насны бүлгийн багцын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулж байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 0-5 насны багц; 2. 6-17 насны багц; 3. 18-30 насны багц; 4. 31-45 насны багц; 5. 46-60 насны багц; 6. 61-ээс дээш насны багц. <p>18-30 насны иргэд 60,000 төгрөгийн 12 нэр төрлийн багцын үзлэг, шинжилгээ, оношилгоо хийлгэх бол 31-45 насныхан 130,000 төгрөг, 46-60 насныхан 150,000 төгрөг, 61-ээс дээш насны иргэд 140,000 төгрөгийн багцын үзлэг, шинжилгээ, оношилгоо тус тус хийлгэнэ. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог оновчтой, хүнд ээлтэй, нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлснээр өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээг гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилтийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх, шаардлагагүй,</p>	НЭМГ, ЭТҮГ, СЭЗГ	90.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>давхардсан шинжилгээний тоог бууруулах, өвчнийг хожуу үе шатанд оношлогдох, хүндрэхээс сэргийлэх, хүүхдийн онцлогт тохирсон үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах боломжтой болсон. Энэхүү эрт илрүүлэгт 2022 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 60.8 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн бөгөөд 2022 оны эхний 11 сарын байдлаар 73 эрүүл мэндийн байгууллагад 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.</p> <p>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 616,519 хүн хамрагдсанаас 279,213 буюу 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 337,306 буюу 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Байршлаар нь харуулбал 314,321 буюу 51.0 хувь нь Улаанбаатар хотод, 302,198 буюу 49.0 хувь нь орон нутагт байна. Үзлэгт хамрагдсан нийт хүний 403,999 буюу 65.5 хувь нь 0-17 насны хүүхэд, 212,520 буюу 34.5 хувь нь 18-аас дээш насныхан байна. Үзлэгийн дүнд өвчлөлийн 327,463 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 213,315 буюу 65.1 хувь нь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 29,730 буюу 9.1 хувь нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 19,650 буюу 6.0 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 19,169 буюу 5.9 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 13,953 буюу 4.3 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин эзэлж байна.</p>		

2	<p>2.2.2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.</p>	<p>Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвөөс гаргасан удирдамж, зааварт үндэслэн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээ”-ний зааврыг 6 удаа шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллаж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлийг үнэлэх салбар хоорондын баг 28 удаа үнэлгээ хийж, цаг үеийн нөхцөл байдалд тохирсон зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлж байна.</p> <p>- Улирлын томуугийн эсрэг дөрвөн цэнт болон гурван цэнт А хүрээний H1N1, H3N2, В хүрээний Austria, Phuket хэв шинжийг агуулсан 2022/2023 оны томуугийн улиралд зөвлөмж болгож буй ДЭМБ-ын батламжтай БНСУ-д үйлдвэрлэсэн 545,000 хүн тун вакциныг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар 19-ний өдрийн А/512 дугаар тушаалаар 21 аймаг, 9 дүүрэгт хуваарилж, улсын хэмжээнд дархлаажуулалтыг зохион байгуулж байна. Нийт хүлээн авсан 545,000 хүн тун вакцины 39 хувь (214.060)-ийг 1-12 хүртэлх насны хүүхдүүдэд, 40.2 хувь (219.230)-ийг 65-аас дээш насныханд, 21 хувь (111.710)-ийг бусад зорилтот бүлэгт (жирэмсэн, ЭМБ, бусад ажил мэргэжлийн шаардлагаар хамрагдах байгууллагууд) хуваарилсан байна. 2022 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд улирлын томуугийн эсрэг вакцины хамралт 49 хувь (267,603)-тай байна.</p> <p>- Улсын хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын байдлаар тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцины 3-р тунгийн хамралт 94.9%, улаанбурхан, гахай хавдар, улаанууд (УГУ)-ын эсрэг вакцины 2-р тунгийн хамралт 94% байна.</p> <p>- Улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 15-21-ны өдрүүдэд КОВИД-19-ын эсрэг вакцины зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 89.6 хувь (нийт хүн амын 68.9%), 2-р тунгийн хамралт 85.7 хувь (нийт хүн амын 66.0%), 3-р тунгийн хамралт 53.7 хувь (нийт хүн амын 31.9%)-тай байна. Өссөн дүнгээр 3-р тунд 1,057,738 хүн, 4-р тунд 139,361 хүн хамрагдсан байна. Өссөн дүнгээр 5-11 насны 3,402 хүүхэд, 12-15 насны 158,923** хүүхэд, 16-17 насны 79,541* хүүхэд, жирэмсэн эмэгтэй 6,428, хөхүүл эмэгтэй 8,020 тус тус 1-р тунд хамрагдаад байна.</p> <p>Дэлхийн банкны төслөөр вакцин биобэлдмэлийн төв агуулах (1,686м² талбайтай, 100 кг хуурай мөс үйлдвэрлэх хүчин чадал</p>	НЭМГ-ХӨХ	100.0
---	--	---	----------	-------

		<p>бүхий үйлдвэртэй)-ыг 3 сарын дотор барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Вакцин, биобэлдмэлийг аюулгүй хадгалах, тээвэрлэхэд хэрэглэх 4.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүйтэн хэлхээний иж бүрэн тоног төхөөрөмж болох</p> <ul style="list-style-type: none"> - Vestfrost VLS-064 маркийн хөргөгч 671 ширхэг; - Vestfrost VLS 504 маркийн хөргөгч 34 ширхэг; - Vestfrost MF314 маркийн гүн хөлдөөгч 64 ширхэг; - Vestfrost VT408 маркийн хэт гүн хөлдөөгч 7 ширхэг; - Вакцин зөөврийн хүйтэн хайрцаг 580 ширхэг; - Вакцин зөөврийн сав 2400 ширхэг; - Хэм хяналтын хэрэгсэл FridgeTag2 3500 ширхэг; - Хөлдөлтийг тандах FreezeTag 3000 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг хүлээн авч, дархлаажуулалтын 580 нэгжийг 100 хувь хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр хангаж, багтаамжийг нэмэгдүүлсэн. <p>Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийн дагуу мэдээлсэн зарим цочмог өвчин (сармагчны цэцэг өвчин болон бага насны хүүхдийн дунд шалтгаан тодорхойгүй, цочмог, хүнд явцтай гепатит)-ийн тохиолдол зөөвөрлөгдөн орж ирэх, дэгдэлт гарахаас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж байна.</p> <p>ОУЭМД (2005)-ийн дагуу мэдээлсэн сармагчны цэцэг өвчний эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр ЭМЯ, ХӨСҮТ, ГЕГ, ЗӨСҮТ, НЭМҮТ, ДЭМБ-ын 28 хүний бүрэлдэхүүнтэй баг Сармагчны цэцэг өвчин Монгол Улсад зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг “Өндөр” гэж үнэлж, 10 чиглэлийн зөвлөмж гаргасан. - 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ЭМЯ, ХӨСҮТ, ГЕГ, ЗӨСҮТ, НЭМҮТ, ДЭМБ-ын 28 хүний бүрэлдэхүүнтэй баг Монгол Улсад сармагчны цэцэг өвчин зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг давтан үнэлэхэд “Дунд” зэргийн эрсдэлтэй гарч, 4 чиглэлийн зөвлөмж гарган хэрэгжүүлж байна. 		
--	--	---	--	--

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
3	2.2.3. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны загвар төвийг нийслэл хотод байгуулна.	Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны загвар төвийг нийслэл хотод байгуулах талаар хийгдсэн ажил байхгүй байна.	НЭМГ, СЭЗГ	0
4	2.2.4. Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Эрүүл мэндийн сайдын тушаал, холбогдох журмын төслийг боловсруулан ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газартай хамтран шаардлагатай эдийн засгийн тооцооллыг хийж байна.	БТГ, НЭМГ, СЭЗГ	50.0
5	2.2.5. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.	"Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дугаар тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн сангийн 5781 дугаарт бүртгүүлсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 616,519 хүн хамрагдсанаас 279,213 буюу 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 337,306 буюу 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Байршлаар нь харуулбал 314,321 буюу 51.0 хувь нь Улаанбаатар хотод, 302,198 буюу 49.0 хувь нь орон нутагт байна. Үзлэгт хамрагдсан нийт хүний 403,999 буюу 65.5 хувь нь 0-17 насны хүүхэд, 212,520 буюу 34.5 хувь нь 18-аас дээш насныхан байна. Үзлэгийн дүнд өвчлөлийн 327,463 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 213,315 буюу 65.1 хувь нь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 29,730 буюу 9.1 хувь нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд, 19,650 буюу 6.0 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 19,169 буюу 5.9 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 13,953 буюу 4.3 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин эзэлж байна.	НЭМГ-ХБӨХ	90.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
6	2.2.6. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.	2022 оны 3 дугаар улирлын байдлаар ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого нийт 474.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 296.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 62.4 хувьтай, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 22.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 18.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 79.9 хувьтай, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 109.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 109.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100 хувьтай төвлөрүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх, цогц үзлэг, шинжилгээнд төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын 79.3 мянган албан хаагчид хамрагдаж, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг оношилгооны шинжилгээнд хамрагдсан нийт иргэдийн 39.4 хувийг эзэлж байна.	БТГ-СУХ	50.0
7	2.2.7. Урьдчилан сэргийлэх анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн өмнөх болон дараах онолын, дадлага сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож хөгжүүлнэ.	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинэчлэн төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн 41, төрөлжсөн мэргэшлийн 197 чиглэлийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар шинэчлэн баталсан ба нэн шаардлагатай байгаа нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх анагаах ухаан судлал, эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал, эмнэл зүйн сэтгэл зүй зэрэг чиглэлийг шинээр баталсан.	БТГ-СУХ, ТЗУГ	70.0
8	2.2.8. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.	Тамхины хяналтын суурь конвенцийг хэрэгжүүлэх 13 байгууллагын 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/762 дугаар тушаалаар байгуулж, 4 зорилт 21 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулж, 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд олон салбарын мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх танхимын сургалт зохион байгуулж, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон Улаанбаатар хотын есөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын 200 мэргэжилтэн, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар болон	НЭМГ-ХБӨХ	90.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>боловсролын байгууллагын 120 алба хаагчийг хамруулж Тамхины хяналтын суурь конвенцийн тухай ерөнхий ойлголтыг дээшлүүлсэн. Тамхины хор хөнөөлийн тухай залуучуудад сурталчлан таниулах сошиал медиа ашигласан 3 сарын аян эхлүүлэн “Тамхинд биш тархиндаа хөрөнгө оруулцгаая” уриан дор 12 төрлийн постер, инфографик, 2 төрлийн видео шторк, 2 төрлийн богино мэдээ боловсруулан сургалт, сурталчилгаа явуулж байна.</p> <p>УИХ-ын Байнгын хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албатай хамтран ажиллаж, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис хэрэглэх донтой хүмүүсийн динамик мэдээлэл болон ажлын хэрэгжилтийн 2017-2021 оны судалгааны ажлын тайлан мэдээлэл; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, донтогчдын судалгаа; Донтох эмгэгтэй иргэдэд үзүүлэх албадан эмчилгээний талаархи мэдээлэл; Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой мэдээлэл солилцон, хамтран ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.4.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ГХЯ-КГ, ТЕГ, ШШГЕГ, ШШҮХ, УБЕГ, ГЕГ, ЭЭХХГ, СЭМҮТ зэрэг 8 байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой мэдээлэл судалгааг шинэчилсэн байдлаар сар бүрийн 28-ны өдөр авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 225 эмч, эмнэлгийн ажилтнуудад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх” сэдэвт сургалт хийж, гарын авлага 500 ширхэгийг тараасан.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн эмч, эрүүл мэндийн хичээл заадаг багш, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч нарт зориулсан “Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлөөс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 1,458 хүнийг хамруулсан. Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт “Электрон тамхинаас хүүхдээ хамгаалья” аян зохон байгуулж Баянзүрх, Багануур дүүрэг, Төв аймагт электрон тамхийг 21 хүртэлх насны хүүхэд, залуучуудад худалдаалахыг хориглосон журам хэрэгжүүлж эхлээд байна.		
9	2.2.9. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай. 2022 оны байдлаар 11 дүгээр сарын байдлаар хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сангаас нийт 1,761,680,710 төгрөгийн санхүүжилт олгосон байна.	НЭМГ-УСХЗХ	70.0
10	2.2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар агуулахын тоног төхөөрөмжийг орлогод авч хуваарилан үндсэн хөрөнгийн бүртгэлд авсан байна. Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг улсын хэмжээний нөөцийн нэгдсэн програм burtgel.mohs.mn-аар өдөр бүр, зах зээлийн нөөц болон импортын мэдээллийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч байна. Зайлшгүй шаардлагатай эм, түүхий эдийн татан авалтыг урьдчилан төлөвлөж, зайлшгүй шаардлагатай эмийн 3-аас дээш сарын нөөцийг бүрдүүлэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад анхаарч	НЭМГ-ХӨХ	100.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>ажиллах тухай чиглэлийг ханган нийлүүлэх байгууллагуудад хүргүүлэн, зохицуулалтыг хийж байна.</p> <p>Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлж ажилласан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 50,166,400 төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моксифлоксациныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон. 2. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавирусын халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,791,815,400 төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг 01 дүгээр сард хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. 3. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 17,008,368 төгрөгийн үнэ бүхий суурилуулах 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,036,754 төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгслийг 02 дугаар сард хүлээн авав. 4. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 85,950,000 төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг 02 дугаар сард хүлээн авч нөөцөд авах тухай тушаал батлуулсан. 5. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 1,799,583,040 төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж үйлчилгээнд 		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>ашиглагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийг 02 дугаар сард хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөв.</p> <p>6. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 595,954,440 төгрөгийн үнэ бүхий явуулын эмнэлэгт суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч 3 дугаар сард хуваарилсан.</p> <p>7. “КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих АСТ-А SFF” механизмын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаас 862,312,500 төгрөгийн үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.</p> <p>8. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 3,849,487,680 төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.</p> <p>9. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 145,555,972 төгрөгийн үнэ бүхий 2 генийн дараалал тогтоогч 9,795,520 төгрөгийн үнэ бүхий генийн дараалал тогтоох шинжилгээний өгөгдлийг унших 2 зөөврийн компьютер, тог баригч, 207,023,772 төгрөгийн үнэ бүхий урвалжуудыг хүлээн авч УНТЭ болон ЗӨСҮТ-д тус тус хуваарилан өгсөн.</p> <p>10. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд дархлаажуулалтын бүртгэл мэдээллийг сайжруулах зорилгоор 1,246,715,344 төгрөгийн үнэ бүхий 548 ширхэг зөөврийн компьютер болон дагалдах хэрэгслийг хүлээн авч улсын хэмжээнд дархлаажуулалтын цэгүүдэд хуваарилан өгсөн.</p> <p>11. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 356,933,850 төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслүүдийг хүлээн авч нөөцөд авах тухай тушаалыг батлуулсан.</p> <p>12. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 33,250,000 төгрөгийн үнэ бүхий 42 ширхэг пульсоксиметрыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.</p> <p>13. Япон Улсын Засгийн газрыг “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,200,011,300 төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг уушгины дуран, 3 ширхэг уушгины мэс заслын багаж хэрэгслийн багцыг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилан олгосон.</p> <p>14. 2021 оны 12 дугаар сард хүсэлт тавьсны мөрөөр НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 847,350,000 үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон.</p> <p>15. Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд SARS-CoV-2 халдварын эсрэг 5-11 насны хүүхдийн вакцин авах хүсэлтийг 2022 оны 04 дүгээр сард КОВАКС-д албан ёсоор хүргүүлж, улмаар 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нийт 1,030,000 тун 5-11 насны хүүхдийн вакциныг Монгол Улсад олгохоор шийдвэрлэсэн тухай албан хариуг хүлээн</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>авсан. Вакцин хүлээн авахтай холбоотойгоор тариур, аюулгүйн хайрцаг зэрэг дагалдах хэрэгслийг КОВАКС-аас авах хүсэлтээ мөн өдөр НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. Вакцин, тарилгыг найруулах уусмалыг АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар олгож байгаа ба олон улсын тээвэр, даатгал, дагалдах хэрэгслийг КОВАКС хариуцаж хангалт хийж байгаа. 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр тарилгын уусмалыг, 18-ны өдөр эхний ээлжийн 302,400 тун вакциныг тус тус хүлээн авсан.</p> <p>16. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөр болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Улс орны (2017-2022)-ийн “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй ба хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт олгосон 536,307,861 төгрөгийн үнэ бүхий 3 явуулын эмнэлэг, ариун цэврийн байгууламжийн чингэлэг, 908,367,975 төгрөгийн үнэ бүхий 3 явуулын эмнэлэгийг хүлээн авч, эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахыг хариуцаж байгаа ЗӨСҮТ-д Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилан олгов. Эдгээр зөөврийн эмнэлэг, ариун цэврийн байгууламжийг хилийн боомтуудад ашиглах ба зөөврийн эмнэлэг тус бүрт эмнэлгийн зориулалтын хөргөгч, эмийн багц, дефибрилятор, өвчтөний хяналтын монитор, зөөврийн ЭХО, амьсгалын аппарат, эмнэлгийн ор, пульсоксиметр, дуслын автомат шахуурга, тариурын автомат шахуурга, хүчилтөрөгч өтгөрүүлэгч суурилуулсан болно.</p> <p>17. НҮБ-ын Хүн амын сан, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын хамтарсан санхүүжилтээр Өргөө, Амгалан амаржих газар болон ЭНЭҮТ-II-т молекул биологийн иж бүрэн лаборатори байгуулж ашиглалтад оруулав. Зөвхөн КОВИД-19-ийн ПГУ шинжилгээ хийх бус бусад халдварт өвчний шинжилгээ хийх чадавхийг бүрдүүлсэн.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>18. НҮБ-ын Хүүхдийн сангаас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд хувийн хамгаалах хэрэгсэл болох 20,000 ширхэг нэг удаагийн хамгаалалтын хувцасны иж бүрдэл, 100,000 ширхэг нэг удаагийн халад болон 20,000 ширхэг нүүрний хаалтыг хүлээн авч, ЭМЯ-ны нөөцөд авав.</p> <p>19. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон нийт 1,082,154,400 төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг спирометрийг 679,546,056 төгрөгийн дагалдах хэрэгслийн хамт хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/550 дугаар тушаалаар 21 аймгийн нэгдсэн эмнэлэг болон ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, НЭМГ-ын харьяа дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд хуваарилан олгов.</p> <p>20. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 5,3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 500,000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, Монгол Улсын 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 331 сумын эрүүл мэндийн төв, НЭМГ-ын харьяа бүх эрүүл мэндийн байгууллагууд, ЭМЯ-ны харьяа болон бусад салбарын харьяаны КОВИД-ын тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх эмнэлэгт Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/556 дугаар тушаалаар хуваарилан олгосон.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
11	2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.	Улсын хэмжээнд нийт 4,952 эрүүл мэндийн байгууллага буюу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 13, тусгай мэргэжлийн төв 15, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 321, өрхийн эрүүл мэндийн төв 208, ортой хувийн эмнэлэг 239, хувийн клиник 1548 байгууллага үйл ажиллагаа явуулж эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газар, АХБ-ны зээлээр хэрэгжиж буй 49173-003-MON “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний өнөөгийн байдалд түргэвчилсэн үнэлгээ хийсэн байна. ЭМАШТУ-ний нөхцөл байдлын үнэлгээний үр дүн, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөц, чанарын удирдлагыг сайжруулах зөвлөмжийг техникийн ажлын хэсгийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Цаашид зөвлөмжийг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.	БТГ-СУХ	50.0
12	2.2.12. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжих хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 239 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 196 буюу 82.0 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. Улс, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ижил тарифаар санхүүжиж байгаа бөгөөд ЭМДҮЗ-ийн 2022 оны “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ батлах тухай” 01 дүгээр тогтоолоор санхүүжиж байна.	БТГ-СУХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
13	2.2.13. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.	<p>Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын тусламж, үйлчилгээний удирдамжийн цахим платформыг нэвтрүүлэн, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийн 1/3-ийг платформиас бүрдүүлэх боломжтой болсон. 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 44,009 хэрэглэгч платформыг ашиглаж, сар бүр платформ хэрэглэгчдийн тоо тогтмол нэмэгдэж байгаа үзүүлэлттэй байна (2022 оны 08 дугаар сард 25,254, 09 дүгээр сард 36,209 хэрэглэгч).</p> <p>Тархи, мэдрэл, зүрх судас, үе мөч, бөөр, уушги, чих хамар, хоолойн зарим өвчин, эмгэг болон нярайн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, эх орондоо бүрэн оношлох, эмчлэх боломжийг бүрдүүлэх талаар санаачлагатай ажиллаж байна. Үүнд: Төрөлхийн, шалтгаан тодорхойгүй нурууны мурийлт оноштой үйлчлүүлэгчид дурангийн мэс ажилбар хийх технологи, Хүзүүний нугалмын хугарал мултралыг арын хүрцээр дагз ястай бэхлэх мэс ажилбар, Тохойны үе бүтэн солих мэс ажилбар, “Цусны бүлэг өөр донор”-оос элэг шилжүүлэн суулгах мэс ажилбар, Мөрний үе солих мэс ажилбар, хиймэл үе хагас солих мэс ажилбар, нээлттэй мөр эргүүлэгч булчингийн шөрмөсний гэмтлийн мэс ажилбар, мөрний үений холбоос сэргээх мэс ажилбар, дурангаар мөр эргүүлэгч булчингийн шөрмөсний урагдал засах мэс ажилбар, Бага хүрцийн буюу дурангийн мэс заслын технологийг нэвтрүүлэхээр дэлүү авах мэс ажилбар, нэг портоор цэсний хүүдий авах мэс ажилбар, дурангаар фондопликаци хийх мэс ажилбар, дурангаар элэгний мэс ажилбар, Кадавер яс болон шөрмөс ашиглан төрөлхийн согог болох Genu recurvatum-г засах мэс ажилбар, өвдөгний үений төрөлхийн мултралыг нэг мэдээ алдуулалтаар өвдөгний үений дотор булууг хэсэгчлэн солих, ард, урд чагтан холбоосыг кадавер шөрмөс ашиглан</p>	ЭТҮГ-АЛШТХ, ТЗУГ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>сэргээх, саран жийргэвчийг сэргээн засах мэс ажилбар, өвдөгний үений тойгны холбоос сэргээх мэс ажилбар, Бөөр шээсний замын чулууг лазер аппаратаар эмчлэх эмчилгээний технологи, Шээсний доод замын хөдлөл зүйн, үргүйдлийн эмгэгийг оношлох, шинжлэх шинжилгээний арга, Тархины судасны катетрт ангиографийн шинжилгээ, Тархины судасны өнгөт хэт авиа дуплекснографийн шинжилгээ, Судсан дотроос спазмолитик эмчилгээ, Нурууны L1 түвшний АВМ-ийг судсан дотроос бөглөх мэс ажилбар, Транс-ораль хүрцээр С2, С3-ийн нугасны буглааг нээх ажилбар болон бусад аргууд болно.</p> <p>Уушги орлуулагч ЭКМО аппаратыг ашиглан 2022 оны 10 дугаар сарын байдлаар УНТЭ 22, УГТЭ 2, ХӨСҮТ 1, ЦТЭ 5, нийт 30 хүнд эмчилгээ хийж, эмчилгээний үр дүн 61.5 хувь байна.</p> <p>Хүүхдийн мэдрэл, мэдрэлийн мэс засал, хүүхдийн сэргээн засалч эмч нарын баг ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн мэдрэлийн эмгэг судлалын кабинетийн хяналтад байдаг саа, саажилттай 230 хүүхдэд идэвхитэй диспансерын хяналтын үзлэг хийж, доод мөчний саатай, мэдрэлийн ёзоор тайрах мэс засал хийх заалттай 22 хүүхэд, мөн 4 мөчний саатай, эцэг, эх нь мэдрэлийн ёзоор тайрах мэс засал хийлгэх хүсэлтэй 67 хүүхдэд хүүхдийн мэдрэл, мэдрэлийн мэс засалч эмч нарын баг үзлэг хийж, MRI шинжилгээнд хамруулсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд мэдрэлийн ёзоор тайрах мэс заслыг Турк Улсын мэдрэлийн мэс заслын багтай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үе шаттай нэвтрүүлж байна. Энэ хүрээнд 5 хүүхдэд мэс заслыг амжилттай хийж, мэс заслын дараах сэргээн засах эмчилгээ хийгдэж байна. Мөн энэхүү тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор УГТЭ, ЭХЭМҮТ, УНТЭ-ийн мэдрэлийн эмч нарыг ажлын байран дээрх сургалтад, харин мэдрэлийн мэс заслын 1 эмчийг Турк Улсад богино хугацааны сургалтанд хамруулсан байна.</p> <p>Мөн дараах томоохон оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд:</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<ul style="list-style-type: none"> - Алло-трансплантац буюу донороос үүдэл эс шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлэх; - Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиглэлээр молекул генетикийн технологиудыг нэвтрүүлж, нутагшуулах; - Нарийн гэдэсний дурангийн оношилгоог нэвтрүүлэхээр ажиллаж байна. <p>Гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэхээр явах иргэдийн урсгалыг бууруулах зорилгоор УГТЭ нь оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тосгуурын фибрилляцийн үеийн хөлдөөх аблаци эмчилгээ; 2. Зүрхний 3D цахилгаан зураглал бүхий ахисан түвшний аблаци эмчилгээ; 3. Гол судасны графт стент суулгах эмчилгээг хийж эхэлсэн байна. Хавдар судлалын үндэсний төвд Австри Улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Хорт хавдрын навигац болон стереотактик эмчилгээний төв байгуулах” төслийн хүрээнд 2022 онд өндөр нарийвчлалтай шугаман хурдасгуур аппарат суурилуулахтай холбоотойгоор тархи, нугасны хавдрын стереотактик туяа эмчилгээг 2023 онд хийж эхлэх бэлтгэл ажил хийгдэж байна. <p>Гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. 2022 оны 06 дугаар сарын байдлаар хувийн хэвшлийн Интермед эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авч, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>		
14	2.2.14. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт	НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод халдварт бус өвчин (ХБӨ)-өөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар “ХБӨ-өөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25%, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний	НЭМГ-ХБӨХ	50.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
	олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.	<p>хомсдлыг 10%, давс, тамхины хэрэглээг 30%, цусны даралт ихсэлтийг 25%, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барих"-аар дэвшүүлсэн. Монгол Улсын Засгийн газар, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр "Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын IV судалгаа"-г 4 жилийн давтамжтай зохион байгуулдаг бөгөөд сүүлийн судалгааг 2019 онд амжилттай зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотыг хамруулсан үндэсний түвшинд 5 жил тутамд "Хүн амын хоол тэжээлийн байдал" үндэсний VI судалгааг 2022 онд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан байна.</p> <p>ДЭМБ-ын санхүүжилтээр ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлж хэрэгжүүлэх төсөл Дорнод, Завхан, Дундговь, Говьсүмбэр, Хөвсгөл, Дархан-Уул зэрэг 6 аймаг, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 132 өрх, сумын эрүүл мэндийн төвд хэрэгжиж байна. Цаашид төслийг Архангай, Хэнтий, Увс, Ховд, Өвөрхангай, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь зэрэг 8 аймаг болон Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүргийн өрх, сумын эрүүл мэндийн төвд өргөжүүлэн хэрэгжүүлэх хүсэлтийг ДЭМБ-д хүргүүлж дэмжигдсэн тул холбогдох бэлтгэл ажлыг хангаж байна.</p>		
15	2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт).	<p>Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулах талаар тодорхой ажлууд хийгдэж байгаа ч санхүүжилтийн асуудлаас болж барилгын төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдаагүй байна.</p> <p>- Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа "Зүрх судасны төв байгуулах" төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжаар Испани Улсын "Идом" ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан.</p>	СЭЗГ-ХОХ	30.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>Барилгын төсвийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй, төсөвгүй гэх шалтгаанаар барилгын гүйцэтгэл гацсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2*30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. - Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, “Хар чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээний төсөл боловсруулах үед “Хар чонот” ХХК нь Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай” 213 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж, тендерийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр дахин зарласан. Дахин зарласан тендерийг “Захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэх тухай” Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан 		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>шатны Шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 128/ШЗ2022/7229 захирамжаар захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна. Барилгын ажлын төсөвт өртөг 18.5 тэрбум төгрөг бөгөөд 2022 оны улсын төсөвт 2 тэрбум төгрөгөөр суусан боловч ажил эхлээгүй. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.</p>		
16	<p>2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.</p>	<p>Улсын хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 100,000 амьд төрөлтөд 33.3 ногдож байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 58.7 пунктээр буурсан байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 12.0 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.5-аар өссөн үзүүлэлттэй байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2022 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд 1000 амьд төрөлтөд 15.2 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6-аар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 52 дугаар тогтоолоор нийслэлийн Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газруудыг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн статустай болгож, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/144, А/145, А/146 дугаар тушаалаар Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрэм, бүтцийг баталсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Эх барихын тусламж, үйлчилгээтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээ, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/313 дугаар тушаалаар</p>	ЭТҮГ-АЛШТХ, НЭМГ-ХБӨХ, УСХЗХ	50.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>”Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй” удирдамжийг батлан мөрдөж байна. Мөн эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Эх барихын яаралтай тусламж”-ийн лекц, дадлага хосолсон сургалтыг Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай аймгуудад зохион байгуулсан. Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах зорилгоор “Эх барихын тусламж үйлчилгээ ба хамтын ажиллагаа”, “Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах нь” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд болон нийслэлийн 9 дүүргийн удирдлага, холбогдох эмч, мэргэжилтнүүдтэй зохион байгуулсан.</p> <p>Бичил тэжээлийн дутлыг бууруулах зорилгоор бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийг бичил тэжээлээр хангах, хүн амд баяжуулсан хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн А аминдэмийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/245 дугаар тушаалаар 5 хүртэлх насны хүүхдэд түгээх хуваарийг батлуулж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хуваарилан, түгээж байна.</p>		
17	2.2.17. Яаралтай түргэн тусламжийн үндэсний тогтолцоог шинэчлэн өөрчилж, онгоц, агаарын тээврийн үйлчилгээг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.	<p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд хийгдэнэ. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд III үе шат буюу 2026 онд төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд судалгааны ажил хийгдэж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын байгууллага нисэх нэгж /111 дүгээр анги/ шинээр байгуулан, агаараас эрэн хайх, аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх ажиллагаанд зориулан тоноглогдсон Airbus EC-145 Т-1 загварын нисдэг тэргийг агаарын тээврийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн. Тус ангийн агаараас тандах дуудлагаар 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс</p>	ЭТҮГ-АЛШТХ, СЭЗГ-ХОХ	30.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>2022 оны 06 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 8 удаагийн аврах ажиллагаа хийгдсэн байна.</p> <p>Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд ОБЕГ, хувийн хэвшлийн байгууллагатай иргэд хувиараа хамтран ажиллаж, нисдэг тэргээр тусламж, үйлчилгээ авч байна.</p> <p>Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна.</p>		
18	2.2.18. Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	<p>Нөөцийг үр ашигтай зарцуулах, санхүүжилтийн зөв тогтолцоог бий болох зорилгоор 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдэд чанартай, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад санхүүжилт олгодог гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн.</p> <p>“Эмзэг бүлгийн хүн амыг эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг бий болгох” зорилтын хүрээнд орлогын ялгаанаас хамаарч эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх нь тэгш байдлыг алдагдуулж, ядуурлыг нэмэгдүүлдэг учраас шинэчлэлийн хүрээнд эмзэг бүлгийн орлого багатай иргэдийг тусламж, үйлчилгээ авах боломжоор хангахад онцгой анхаарсан. Нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд “хүчтэй нь хүчгүй нэгнээ, орлого ихтэй нь орлого багатай,</p>	БТГ-СУХ, ЭТҮГ-АЛШТХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>хөдөлмөрийн чадвартай нь хүүхэд, хөгшдөө” халамжлах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурладаг. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын нэг гол хэсэг нь хүн амын тэгш байдлыг хангах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилготой дээрх зарчим бүрэн нийцдэг. Иймд иргэний хариуцан төлөх төлбөр буюу хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулсан. Хамтын төлбөрийн бодлогыг хүн амын бүлгээр болон тусламж, үйлчилгээний нэр төрөлд суурилсан үндсэн 2 хэлбэрээр олон улсад хэрэгжүүлдэг. Монгол Улсын хувьд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн буюу үүнд хавдар, сэтгэц, харвалт, шигдээс, түлэгдэл гэх мэт хүний амь нас цаг хугацаагаар хэмжигддэг тусламж, үйлчилгээнд хамтын төлбөргүй байх, мөн ахмад, жирэмсэн болон хөхүүл эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, цэргийн албан хаагч гэх мэт төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн тусламж, үйлчилгээ авахдаа төлөх төлбөрөөс чөлөөлсөн. Тухайлбал хүнд зэргийн түлэгдэлтэй хүүхдийг эмчлэхэд дунджаар 38 сая төгрөгийн зардал гардаг бөгөөд “гүйцэтгэлийн санхүүжилт”-ээс өмнө зардлын 25 хувийг буюу 10 сая төгрөгийг иргэн өөрөө хариуцдаг байсныг болиулсан. Энэхүү хөнгөлөлтөд 1 сая орчим иргэд давхардсан тоогоор хамрагдсан бөгөөд хамтын төлбөрийн чөлөөлөлттэй холбоотой 2022 онд ЭМД-ын сангаас 48 тэрбум төгрөгийг төлсөн байна. Эмийн үнийн хөнгөлөлтийн хувьд удаан хугацаагаар насан туршдаа уудаг эмүүдийг 70 хүртлэх хувиар хөнгөлж, тогтмол санхүүгийн дарамтад орохоос сэргийлсэн.</p> <p>Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтын удирдамж"-ийн дагуу Зүүн, Баруун, Төв, Хангайн бүсийн сургалтыг 2022 оны 04-05 дугаар сард зохион байгуулж, 373 албан хаагчийг хамруулсан.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран 2022 оны 05 дугаар сарын 10, 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн төлөөлөлтэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулж байна.</p> <p>Тархины саа, саажилт, уналт таталт оноштой байнгын диспансерийн хяналтад байдаг 19 хүртэлх насны хүүхдийн байнга хэрэглэдэг эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэй олгох асуудлыг шийдвэрлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан. ЭМДҮЗ-ийн 2020 оны 13 дугаар тогтоолоор олон улсын нэршил бүхий 11 ерөнхий нэршлийн 41 худалдааны нэршлийн эмийг 70 хувийн үнийн хөнгөлөлт үзүүлж байсан бол 2022 оны 11 дүгээр тогтоолоор олон улсын нэршлээр 25, худалдааны нэршлээр 78 нэр төрлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p>		
19	2.2.19. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.	<p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасны дагуу Засгийн газрын 2021 оны 408 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын 2022 оны шимтгэлийн хувь, хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, 0-18 насны хүүхэд, оюутан, суралцагчдад ХХДХ-ийн 1 хувь, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувь байхаар тогтоосон байна.</p> <p>2022 оны 3 дугаар улирлын байдлаар ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого нийт 474.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 296.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 62.4 хувьтай, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 22.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 18.3 тэрбум</p>	БТГ-СУХ, СЭЗГ-СДХ	30.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>төгрөгийг төвлөрүүлж 79.9 хувьтай, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 109.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 109.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100 хувьтай, төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө 360.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 495.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100 хувьтай, бусад орлого 2.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.</p> <p>2022 оны 3 дугаар улирлын байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хамралт 87%, малчдын хамралт 44.3%, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын хамралт 31.2% байна.</p>		
20	2.2.20. Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	<p>Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээнд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ЭМЯ-тай хамтран ажиллах заалтыг тусгасан. Энэ хүрээнд ЭМЯ-аас аймаг, нийслэлийн ЗДТГ, нэгдсэн эмнэлгийн дарга, эмнэлгийн ҮЭ-ийн хороо, залуучуудын зөвлөлд ТУЗ байгуулах ажлыг хууль, журмын дагуу хамтран зохион байгуулахыг мэдэгдэж албан тоотыг 2022 оны 01 дүгээр сард хүргүүлсэн.</p> <p>УНТЭ, УГТЭ, АӨСҮТ-өөс гадна Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 5 байгууллагад ТУЗ шинээр байгуулагдан ажиллаж эхэлсэн байна.</p> <p>ХСҮТ, ГССҮТ, УХТЭ, Дорнод аймаг дахь БОЭТ, Архангай, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 6 байгууллагад ТУЗ байгуулах үйл ажиллагаа дууссан болон батламжлах шатанд байна.</p> <p>Дундговь, Баян-Өлгий, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Орхон, Өмнөговь, Ховд аймаг дахь БОЭТ-үүдэд ТУЗ зөвлөл байгуулах үйл ажиллагаанууд эхэлсэн (6 байгууллага).</p>	ТЗУГ, СЭЗГ-СДХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн олон нийтийн төлөөлөл болон эмнэлгийн хамт олны төлөөллийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн ЗДТГ-аас явуулахдаа хууль, журам, удирдамж зөрчин явуулсан тул дахин зохион байгуулах саналыг ЭМЯ-аас хүргүүлээд байна.</p> <p>Нийт 21 эрүүл мэндийн байгууллагад ТУЗ байгуулагдаж, байгуулагдах шатандаа байна. Үүнээс 8 эрүүл мэндийн байгууллагад ТУЗ ажиллаж байна.</p> <p>Дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн бүтэц, зохион байгуулалтыг эрүүл мэндийн хуульд нийцүүлэн өөрчилж, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах боломж бүрдүүлэх чиглэлийг НЭМГ-т хүргүүлсэн хэдий ч дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн өөрчлөх үйл ажиллагаа удаашралтай байна.</p>		
21	2.2.21.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төрөөс хараат бус бие даасан магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/143 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл болон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төлбөрийн жишиг тогтоосон журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, журмын төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.	БТГ-СУХ, ТЗУГ	30.0
22	2.2.22. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын ЭМТ, лавлагаа шатлалын 64 эмнэлгийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрсэн. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнг үнэлж, үнэ тарифын өсөлт, цалингийн доод жишиг шинэчлэхтэй холбоотойгоор уг журмыг дахин шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын ЭМТ, лавлагаа шатлалын 64 эмнэлгийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрсэн. 562 оношийн хамааралтай бүлгийг 705 болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээ, өдрийн мэс засал, ажилбар, эмчилгээг даатгалаас санхүүжүүлэхээр жагсаалтыг өргөжүүлсэн. Мөн ЭМДҮЗ-ийн	СЭЗГ-СДХ	100.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журам”-ын хэрэгжилт, үр дүнг үнэлж, журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор батлуулж анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн уялдаа холбоог хангасан байна.</p> <p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 239 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 196 буюу 82.0 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд тус журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулагдсан. Сонгон шалгаруулалтаар 196 хувийн эмнэлэг 9 нэр төрлийн 9,055 оношийн хамааралтай бүлгээр тэнцэж гэрээлсэн байна.</p>		
23	2.2.23. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно.	<p>УАУ-ны тусламж, үйлчилгээг хослуулан хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үр дүн, нотолгоо судалгааг дэмжих, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, экспортод гарах гарцыг тодорхойлоход “Уламжлалт анагаах ухааны салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв: Асуудал, шийдэл” улсын зөвлөгөөнийг БШУЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ХНХЯ, бусад төр, хувийн хэвшлийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангасан цахим болон тэнхим хосолсон хэлбэрээр 2022 оны 06 дугаар сард зохион байгуулж, УАУ-ны салбарыг хөгжүүлэхэд цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойллоо.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” тушаалд Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд уламжлалтын тусламж, үйлчилгээний шалгуурыг тусгайлан тусгасан, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/55 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал, оношийн кодыг шинэчлэн батлуулсан. Уламжлалт анагаах ухааны бие даасан оношийн ангилал, өртөг зардал тодорхой</p>	ЭТҮГ-УАУХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>болж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд УАУ-ны оношилгоо эмчилгээний бүртгэл тоон мэдээллийн сан үүсэж, зонхилон тохиолдох өвчлөл, эмчилгээний нэгдсэн мэдээлэл гарах боломжийг бүрдүүллээ.</p> <p>УАУ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн сургалтад орон нутагт УАУ-ын дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төр, хувийн хэвшлийн 40 гаруй эрүүл мэндийн байгууллагын төлөөлөлийг хамруулав. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индексд уламжлалт анагаах ухааны төгсөлтийн дараах сургалтын үндсэн мэргэшил 6 чиглэлээр, төрөлжсөн мэргэшил 13 чиглэлээр төрөлжсөн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэлд УАУ-ны эмнэлзүйн болон уламжлалт эмийн чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийг тусгажээ. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/208 дугаар тушаалаар “Эмийн чанар аюулгүй байдлыг судлах” дэд ажлын хэсэг байгуулж, эмийн бүртгэлийн Licemed эмийн бүртгэлийн программд бүртгэлтэй уламжлалт эмийн судалгааг хийж байна. Уламжлалт эмийн үйлдвэрүүдэд эмийн үйлдвэрийн зохистой дадал (GMP)-ыг хангуулахад чиглэсэн сургалтыг зохион байгуулж, дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэх юм.</p> <p>Уламжлалт анагаах ухааны эмийн 7 ерөнхий хэлбэрээр (талх эм, тан эм, амирлуулах эм, архин эм, тосон эм, үнсэн эм, зуурмал эм) фармокопейн төслийг боловсруулж байна. Эрүүл мэндийн яамнаас Монгол хүний оюуны үнэ цэнэ шингэсэн уламжлалт анагаах ухааны бүтээл туурвилыг гадаад, дотоодын түүхэн сурвалжаас нэгтгэн эмхэтгэн нийтийн хүртээл болгох үйл ажиллагааг дэмжин эхний 27 ботийг түгээхэд бэлэн болгожээ.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
24	2.2.24. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, импорт, түгээлт, цахим хяналтын тогтолцоо бүхий эмийн зохицуулалтын нэгдсэн байгууллага байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 80 байхаар баталсан. ЭЭХХЗГ нь 7 газар (Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Чанарын хяналтын газар, Эм шинжлэх лаборатори, Захиргаа, удирдлагын газар, Эм хангамжийн газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар) болон Эмийн бүртгэлийн болон Эм үйлдвэрлэлийн хэлтэстэй үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын 28, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийн 24, нийт 52 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт орон тоо, цалингийн сан, холбогдох зардлын хамт 2021 оноор тасалбар болгон шилжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тоог 132 болгон нэмэгдүүлсэн. Засгийн газрын 222 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа болно.	БТГ-СУХ	100.0
25	2.2.25. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (телемедицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/129 дугаар тушаалаар “Телемедициний үндэсний сүлжээний ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ-т телемедицин ашиглаж байна. Мөн Эрчимт эмчилгээний тасгуудын хооронд телемедициний сүлжээ байгуулах үйл ажиллагааны хүрээнд ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ЦТЭ зэрэг 6 эрүүл мэндийн байгууллагыг холбон, үйл ажиллагааг жигдрүүлсэн. Коронавируст халдварын үеийн эрчимт эмчилгээний зөвлөх багийг байгуулж орон зай,	БТГ-СТХ	100.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>цаг хугацаанаас үл хамааран эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг цаг алдалгүй зохион байгуулах зорилгоор ЭМХТ-д сервер нь байрлах lifesize программын application-ийн ашиглах эрхийг 21 аймаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүдэд худалдан авч ашиглах зааврын хамт хүргүүлсэн. Ингэснээр эрчимт эмчилгээний тасгийн ажилчид гар утас болон зөөврийн компьютер зэрэг төхөөрөмжүүдээс холбогдож зөвлөгөө, мэдээлэл авсан бичлэг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн серверт хадгалагддаг давуу талтай болсон. Мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор телемедициний үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжтой болсон.</p> <p>Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эхлүүлснээр иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ илүү ойртож хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан. Тухайлбал, эмнэлэгт үзүүлэх цаг захиалгын үйлчилгээ, лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн магадлагаа, вакцины гэрчилгээ, вакцинжуулалтад хамрагдсан талаарх QR код, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт гэх мэт үйлчилгээг бүрэн цахимжуулж E-mongolia системээс авах боломжтой болсон.</p> <p>Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрхний төвийн санаачилгаар Алсын зайн анагаах ухааны систем МН кардио програм хангамжийг ашиглах талаар ЭМЯ-ны Техникийн хороо болон Мэдээллийн технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ашиглах шийдвэр гарсан. Тус програмд хувийн 4 эрүүл мэндийн байгууллага, анхан шатлалын 212 эрүүл мэндийн байгууллага, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон 9 дүргийн эрүүл мэндийн төв, ЭМЯ-ны харьяа 4 байгууллага холбогдон зүрх судасны чиглэлээр эмнэлзүйн хэлэлцүүлэг, хариу зөвлөгөө зэрэг үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн 2013 оноос эрүүл мэндийн хөгжлийн төвд телемедициний холлолболтын суурь тоног төхөөрөмж сурилуулан 16 төрөлжсөн</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		эмнэлэг, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, 2 дүүргийн эмнэлгийг холболтын тоног төхөөрөмжөөр ханган холбогдон ажиллаж байна.		
26	2.2.26. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 222 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг шинээр байгуулсан. Уг агентлагийн бүтцэд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрыг шинээр бий болгож, хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоотой болох юм. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэр томъёоны толь бичиг, БНЭУ-ын Эрүүл мэндийн яамнаас гаргасан хэрэглэгчид зориулсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үйлчилгээний гарын авлага”, MNS 5081:2013 “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” стандартыг үндэслэн 27 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан цахим гарын авлага хэлбэрээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргэж, нэгдсэн удирдлагаар хангаж байна.</p> <p>Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний 2 ширхэг автомашин (явуулын лаборатори) нийлүүлэгдэнэ. Гэрээний дагуу 2022 оны 06 дугаар сараас эхлэн автомашины нийлүүлэлт эхлэхээр байсан боловч Украин Улсад болж буй дайны улмаас тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн эд ангиудын нийлүүлэлт тасалдаж, гэрээний нийлүүлэлтийн хугацаа хойшилсон. 2022 оны 12 дугаар сарын дундуур тээвэрлэлт хийгдэж эхлэх талаар гүйцэтгэгч байгууллагаас мэдээлэл ирүүлсэн байна.</p>	БТГ-СТХ	50.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
27	2.2.27. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар 2021 онд баталгаажуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 30 ортой сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан. Зургийг 2023 оноос эхлэн ашиглаж барилга байгууламжийг барина. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тушаалаар Эмнэлгийн барилгын норм, дүрмийг баталсан.	СЭЗГ-ХОХ	70.0
28	2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдварын оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоог сайжруулахаар дараах хөрөнгө оруулалтууд хийгдсэн. - Аймаг, нийслэлд молекул биологийн лаборатори байгууллаа 2021 онд улсын хэмжээнд 17 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, Шивээхүрэн, Гашуунсухайт зэрэг хилийн боомт, нийт 27 газар бодит хугацааны ПГУ, нуклеин хүчил ялгах 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий молекул биологийн лаборатори байгуулсан. 2022 онд Булган, Төв, Дундговь аймагт молекул биологийн лабораторийг шинээр байгуулж ашиглалтад оруулсан бөгөөд нийт 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт молекул биологийн лаборатори байгуулагдаад байна. Молекул биологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 202 лабораториудад 2022 оны 4 дүгээр сард олон улсын гадаад чанарын хяналтыг явуулсан. - Бүх Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд), хэнтий аймагт 1.7 тэрбум төгрөг (нэгж үнэ) бүхий ангиографийн аппаратаар хангав;	ЭТҮГ-АЛШТХ, СЭЗГ-ХОХ	100.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>- 64 зүслэгтэй компьютер томографын аппаратаар 6 аймагт (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 5) хөрөнгө оруулалт хийсэн (8.2 тэрбум төгрөг);</p> <p>- 17 эрүүл мэндийн байгууллагад 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий зөөврийн рентген аппарат;</p> <p>- хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр 16-г байгууллаа, 9.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар;</p> <p>- эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад 3,000 компьютер хүлээлгэн өглөө (5.9 тэрбум төгрөг).</p> <p>Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээг сайжруулах төсөл арга хэмжээг зохион байгуулан дэвшилтэт технологи бүхий 17 нэр төрлийн 92 ширхэг тоног төхөөрөмжийг 18.6 тэрбум төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр хангалтыг хийж үйл ажиллагаанд оруулаад байна.</p> <p>Улсын төсвийн санхүүжилтээр Германы Siemens үйлдвэрийн Artis Zee маркийн Ангиографийн аппаратыг Орхон, Дорнод, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Ховд зэрэг 6 аймагт суурилуулан Зүрхний ишеми, Цочмог шигдээс, Элэгний хавдрын үед хийгдэх TACE эмчилгээ, Тархины судасны оношилгоо, Диализийн туннель, Хөлийн тараагуур судасны оношилгоо зэрэг тусламж, үйлчилгээг хийж байна. Ангиографийн аппаратыг орон нутагт суурилуулснаар иргэдийг оношилгоонд эрт хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл рүү чиглэсэн төвлөрлийг сааруулах, иргэдэд эдийн засгийн хувь хэмнэлт үүсгэж байна.</p> <p>Мөн орон нутагт өмнө нь оношлох боломжгүй байсан, ялангуяа хол зөөвөрлөх боломжгүй тархи, нугас, зөөлөн эдийн гэмтлийн үед тухайн газар нь тусламж, үйлчилгээг үзүүлдэг болсон нь ихээхэн ахиц дэвшил юм.</p>		
29	2.2.29. Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангаж, эмч,	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын	БТГ-СУХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
	эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.	05-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар батлуулж, төгсөлтийн өмнөх, дараах сургалтаар бэлтгэх тогтолцоо, нийгмийн баталгааны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 2026 он хүртэлх эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг мэргэжил, мэргэшлээр гаргасан. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн 2022 оны 107 дугаар тогтоол батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү тогтоолоор эрүүл мэндийн салбар (ТҮЭМ, ТҮ)-ын ажилчдын үндсэн цалингийн доод жишигтэй байх, цалингийн шатлалгүй байх өөрчлөлт оруулж үндсэн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 5 дугаар шатлалын дүнгээр баталсан. Тогтоолын дагуу ТҮЭМ ангиллын ажилчдын үндсэн цалин ажилласан жилээс хамааран 0-14.2 хувиар өссөн бөгөөд өсөлтийн дундаж хувь 7.8 байна.		
30	2.2.30. Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн захирлын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн хөтөлбөрөөр сургалт эрхлэгч боловсролын байгууллагад олгох тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг боловсронгуй болгох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлагдсан ба ажлын хэсэгт Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулиас төлөөлөл орсон. Ажлын хэсгийн зүгээс өндөр хөгжилтэй бусад улс орны туршлагыг судалж, БНХАУ, Австрали, АНУ-ын тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, заавар, Дэлхийн анагаахын холбоо (World Medical Association)-ны шаардлага, зааврыг орчуулж нэгтгэл хийсэн. Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох	БТГ-СУХ, ТЗУГ	30.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагын шинэчилсэн төслийг эхний байдлаар боловсруулсан ба ажлын хэсгийн зүгээс тус төслийг танилцуулах хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сард багтаан хийхээр төлөвлөж байна.		
31	2.2.31. Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрт тусган эрүүл амьдралын зан үйлийг хэвшүүлнэ.	2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн тодорхой хугацаагаар тасраад байсан ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн сургалтын хөтөлбөр орж эхэлсэн. Боловсрол, шинжлэх ухааны, соёл, спортын сайдын 2018 оны А/453 дугаар тушаалаар “Эрүүл мэнд” хичээлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. IV-XII дугаар ангийн сургалтын хөтөлбөрийн агуулгад үндсэн 6 сэдвийн 1 нь хооллолт, хоол тэжээлийн асуудал юм. Хувийн болон орчны эрүүл мэнд; Хооллолт, хөдөлгөөн; “Сэтгэцийн эрүүл мэнд”; “Хорт зуршил”; Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон Жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг бүлгийг оруулснаар хүүхэд, өсвөр үеийг сэтгэцийн тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн зөв дадал, хэвшилтэй болгоход чухал ач холбогдолтой. Харин I-III дугаар ангийн сурагчдад эрүүл мэндийн хичээлийг “Хүн ба орчин”, “Хүн ба байгаль”, “Хүн ба нийгэм” болон “Биеийн тамир” хичээлээр хавсран сургах юм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Эрүүл мэндийн боловсрол” эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр боловсруулагч, сурах бичиг зохиогч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан гарын авлага хэвлэгдэн гарсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон НҮБ-ын Хүүхдийн сан, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг, эхийн боловсролыг дэмжих нь” арга зүйн зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна. Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн “Эрүүл мэнд” хичээлийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ	НЭМГ-УСХЗХ	30.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу 2022 оны 09-12 дугаар сард нийслэл, 5 аймагт хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна.		
32	2.2.34. Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг, чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.	<p>1. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан 2021 оны А/758, А/197 дугаар тушаалаар батлагдсан “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь, хэмжээ, “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах мэргэжлээс шалгаалсан өвчний жагсаалт”-ыг танилцуулах бүсчилсэн сургалтыг Баруун бүсэд 2022 оны 03 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд, Зүүн бүсэд 2022 оны 03 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд, Төвийн бүсэд 03 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд 350 гаруй эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын бүрэлдэхүүнийг оролцуулан тус тус зохион байгуулсан.</p> <p>2. Эмнэлэг хөдөлмөр магадлах төв комисс, эмнэлэг хяналтын төв комиссын эмч нарыг чадавхижуулах, сургагч бэлтгэх сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан сургалтад 170 гаруй эмнэлгийн мэргэжилтэн оролцсон.</p> <p>3. Сул харааны бэрхшээлтэй хүний тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэх салбар дундын хэлэлцүүлэгт 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр оролцсон.</p> <p>4. Агаарын тээврийн хялбаршуулсан үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн яамнаас “Агаарын тээврээр үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан зэрэг тусламж, дэмжлэг шаардлагатай иргэдэд үйлчлэх агаарын тээврийн үйлчилгээний ажилтанг чадавхижуулах сургалтыг 2022 оны 04</p>	НЭМГ-УСХЗХ, ЭТҮГ-АЛШТХ	70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		сарын 06-аас эхлэн нэг сарын хугацаатай бүсчилсэн байдлаар зохион байгууллаа. Эрүүл мэндийн яамнаас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчин, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” нь сургалтын удирдамжийг боловсруулан баталж бүсчилсэн сургалт зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн Дорнод, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийн яамны 3/1393 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаа. Бүсчилсэн сургалтанд нийт 127 иргэний нисэхийн албан хаагчийг оролцуулан зохион байгуулсан.		
33	2.2.35. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна.	2022 оны 01 дүгээр сарын 20-ноос АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, АНУ-ын Лома Линда их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эрүүл мэндийн судалгааны төвтэй хамтарсан “Тамхинаас гарах эмийн болон зан үйлийн эмчилгээний үр дүнгийн судалгаа”-г 1,000 хүнийг хамруулан хийж, хамтран ажилаж байна.	НЭМГ-ХБӨХ, ЭТҮГ-ЭТЧАБХ	30.0
34	2.2.36. Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.	ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 650 нэр төрлийн “Өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээний хэрэгсэл”-ийн зардлыг тусад нь санхүүжүүлж, зардлын 25 хувийг иргэн төлдөг байсныг өөрчилж, үндсэн мэс заслын өртөгт нь шингээж цогцоор нь санхүүжүүлдэг болгож иргэнийг санхүүгийн эрсдлээс хамгаалсан. Хамгийн өндөр үнэтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болох эрхтэн шилжүүлэх үйлчилгээний нийт зардал (113.6 сая төгрөг)-ын 75 хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Хэвтүүлэн эмчлэх эмэн тусламж, үйлчилгээг даатгуулагчийн биеийн байдлын хүнд, хөнгөн зэргээс нь хамааруулан, ялгаатай тарифаар санхүүжүүлэхээр оношийн хамааралтай бүлгийг “А-буюу хүнд”, “Б-буюу хөнгөн” гэж ангилсан бол мэс заслын тусламж, үйлчилгээг өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй	ЭТҮГ-АЛШТХ, СЭЗГ-СДХ	100.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>үйлдлээс нь хамааруулан А, В, С гэж ангилж санхүүжүүлж байна.</p> <p>2021 онд өндөр өртөгтэй дуран, компьютер томографи, MRI оношилгоо, 2022 онд шинээр цөмийн оношилгоо, эмчилгээ болох ПЭТ-компьютер томографи оношилгоо, Иод-131 эмчилгээ, хорт хавдрын бай эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлж өргөжүүлсэн.</p> <p>Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" 49/А/118 дугаар хамтарсан тушаалаар баталсан оношилгоо, шинжилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний жагсаалтад хамаарах, оношилгоо, шинжилгээ, тэдгээрийн өртгийн жин, ЭМД-ын сангаас болон иргэний хариуцан төлөх төлбөрийн хэмжээг тооцоолон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/53 дугаар тушаалаар батлуулжээ. Уг тушаалд багажийн, биохимийн, гематологи, иммунологи, молекул биологи, эд нийцлийн, эд эсийн, хэт авиа, рентген оношилгоо бусад төрлийн нийт 411 оношилгоо, шинжилгээ багтсан байна.</p>		
35	2.2.37. Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	<p>Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээнээс сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх бодлогыг баримталж нэг оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлж байсныг 12 ялгаатай бүлэг болгохын зэрэгцээ, ялгаатай оношийн хамааралтай бүлэг бүрийн өртгийн судалгааг хийн, төлбөрийн хэмжээг тодорхойлж ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 болон 2022 оны 01 дүгээр тогтоолоор журамласан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж сэргээн засах тусламж, үйлчилгээний суурь тарифыг 250,000 төгрөг байсныг 700,000 төгрөг болгож дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх хэвтүүлэн эмчлэх 10 оношийн хамааралтай бүлэг, амбулаторийн</p>	БТГ-СУХ, СЭЗГ-СДХ	90.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		тусламж, үйлчилгээ болон өдрийн эмчилгээний тус бүр 1 оношийн хамааралтай бүлгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцан санхүүжүүлж байна.		
36	2.2.38. Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломжийг бүрдүүлнэ.	Халдварт өвчин судлалын төвд бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо болон сүрьеэ өвчний дүрс оношилгоонд хиймэл оюун ухаан ашиглах судалгааны ажлыг эхлүүлээд байна.	БТГ	30.0
37	2.2.39. Алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ.	2022 онд 23 ЭМАШТУ үзүүлэгч байгууллага "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2022 оны сүүлийн хагас жилд нийслэл, орон нутгийн 56 анхан шатны эрүүл мэндийн байгууллага мобайл технологийг өргөжүүлэх арга хэмжээнд хамрагдаж мобайл тоног төхөөрөмжийн багцыг хүлээн авсан байна. Завхан, Ховд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг тоног төхөөрөмжийг хэрхэн хэрэглэх ашиглах талаар сургалтад хамруулсан. "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ" сэдэвт сургалт туршлага солилцох арга хэмжээг Сүхбаатар аймагт 2022 оны 04 дүгээр сарын 18-21, Баянхонгор аймагт 2022 оны 05 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 142 хүнийг хамруулсан.	БТГ	30.0
Зорилт 2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.				
38	2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.	Монгол Улсад нярайн төрөлхийн гаж хөгжил нэмэгдэж, нялхсын эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг хэвээр байсаар байна. Сүүлийн 10 жилийн байдлаар буюу 2011-2021 онд нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн дотор төрөлхийн хөгжлийн гажиг 14.3 хувийг эзэлж байна. Бүс нутгаар нь авч үзвэл Хангай бүсэд илүүтэй зонхилж байна. Эрүүл мэндийн статистик мэдээллээр 2014-2021 онд нийт амьд төрөлтийн 0.7 хувьд нь төрөлхийн гажгийн тохиолдол бүртгэгдэж байна. Нэг хүртэлх насны хүүхдэд төрөлхийн гажиг 2011 онд 960 тохиолдол, 2012 онд 1,262, 2013 онд 865, 2014 онд 1,202, 2015 онд 1,105, 2016 онд 978, 2017 онд 2,674, 2018 онд 3,868, 2019 онд 4,243, 2020 онд		50.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>3,553, 2021 онд 4,337 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Нэг хүртэлх насны хүүхдэд бүртгэгдсэн төрөлхийн гаж хөгжлийн тохиолдлыг сүүлийн 10 жилээр харахад 4 дахин нэмэгдсэн байна. Бүртгэгдсэн төрөлхийн гажиг дотор зүрх, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг, шээс ялгаруулах тогтолцооны төрөлхийн гажиг, сэтэрхий уруул ба тагнай, хоол боловсруулах тогтолцооны төрөлхийн гажиг, түнхний төрөлхийн гажиг тэргүүлэх байрыг эзэлж байна. Судалгааны үр дүнгээс харахад Дауны хам шинж 45.7%, Эдвардсын хам шинж 21.4%, бусад хам шинж 32.9% тус тус байна.</p> <p>35-аас доош насны эхийн урагт 30.4%-д нь хромосомын эмгэг оношлогдсон нь жирэмсэн эмэгтэйчүүд нас харгалзахгүй пренатал илрүүлэг шинжилгээнд хамруулах, эрсдэлийг тооцох шаардлага гарсан байгааг харуулж байна. Төрөлхийн хөгжлийн гажгийг эрт оношлох зорилгоор жирэмсний эхний 3 сард ургийн хромосомын гажгийг илрүүлж оношлох; хромосомын гажгийн оношийг ураг орчмын шингэний шинжилгээг авч генетикийн лабораторит кариотоп тодорхойлж оношийг батлах; жирэмсний 18-22 долоо хоногтойд өндөр хүчин чадалтай хэт авиан шинжилгээгээр бүтцийн гажгийг оношлох; ургийн мэс засал (дуран болон нээлттэй) эмчилгээг нэвтрүүлэх чадамж бүхий Нярайн скрининг, удамзүйн оношилгооны төв байгуулах Пренатологийн төв байгуулах ажлын үндэслэл, тооцоог боловсруулсан.</p> <p>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд Засгийн газрын хөрөнгө оруулалтаар ЭХЭМҮТ-ийн Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн өргөтгөлийн барилгыг 7.9 тэрбум төгрөгийн санхүүжих өртөгтэйгөөр барьж, 2023 онд хүлээлгэн өгөхөөр барилга, зургийн ажил хийгдэж байгаа ба тус өргөтгөлд Анагаахын удамзүйн скрининг, оношилгооны төв нь Цитогенетик, Молекул генетик, Хавдрын генетик, Нярайн скрининг зэрэг нэгжүүдтэй байхаар лабораторийн зураг төслийн ажил батлагдсан байна.</p>		

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/284 дүгээр тушаалаар ЭХЭМҮТ болон Хүрээ амаржих газарт 490.0 сая төгрөгийн өртөг бүхий Удамзүйн лабораторийн тоног төхөөрөмж хуваарилжээ.		
39	2.7.4. Ургийн үеэс эхлэн монгол хүний насны онцлогт тохирсон эрүүл мэнд-бие бялдар, боловсрол, эх оронч хүмүүжил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	<p>2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн тодорхой хугацаагаар тасраад байсан ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн сургалтын хөтөлбөр орж эхэлсэн. Боловсрол, шинжлэх ухааны, соёл, спортын сайдын 2018 оны А/453 дугаар тушаалаар “Эрүүл мэнд” хичээлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. IV-XII дугаар ангийн сургалтын хөтөлбөрийн агуулгад үндсэн 6 сэдвийн 1 нь хооллолт, хоол тэжээлийн асуудал юм. Хувийн болон орчны эрүүл мэнд; Хооллолт, хөдөлгөөн; “Сэтгэцийн эрүүл мэнд”; “Хорт зуршил”; Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон Жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг бүлгийг оруулснаар хүүхэд, өсвөр үеийг сэтгэцийн тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн зөв дадал, хэвшилтэй болгоход чухал ач холбогдолтой. Харин I-III дугаар ангийн сурагчдад эрүүл мэндийн хичээлийг “Хүн ба орчин”, “Хүн ба байгаль”, “Хүн ба нийгэм” болон “Биеийн тамир” хичээлээр хавсран сургах юм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Эрүүл мэндийн боловсрол” эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр боловсруулагч, сурах бичиг зохиогч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан гарын авлага хэвлэгдэн гарсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон НҮБ-ын Хүүхдийн сан, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг, эхийн боловсролыг дэмжих нь” арга зүйн зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна.</p> <p>Хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн сайдын тушаалаар арга хэмжээний төлөвлөгөөнүүд батлагдсан. Тухайлбал,</p>		70.0

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт	Тайлагнах газар, хэлтсийн нэр	Үнэлгээний хувь, %
		<p>“Орчны эрүүл мэнд” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаал, “Хавдрын эсрэг” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаал, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаал, “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаал, “Эрүүл идэвхтэй амьдрал 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаал, “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаал, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар тус тус батлуулан хэрэгжүүлж байна.</p>		
ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ			62.8	

Эрүүл мэндийн яам
2022 оны 11 дүгээр сар